

MADE BY MEMORY

First Chapter

Агуулга

“Дурсамжаар бүтээв” нь уран бүтээлч Х.Сүрэнгийн 2021-2022 онд дэлгэгдэх таван цуврал концепт бүтээл бөгөөд өөрийн дурсамжуудыг янз бүрийн цаг үед төрж буй өнцгөөр баяжуулан гаргаж буй ажил юм. “Дурсамжаар бүтээв-Нэгдүгээр бүлэг” үзэсгэлэнгийн үндсэн хэсэг нь Х.Сүрэнгийн 2013-2016 онд Итали улсын Болонья хотод сурч амьдарч байхдаа хийсэн бүтээлүүд, үлдэж буй нь 2020 онд хийсэн ажлууд болно.

Эдгээр ажлуудыг дүрслэх урлагийн зураасан болон бар зургийн техникүүд, хатгамлын техник зэргийг ашиглаж хийжээ. Үзэсгэлэнд бүтээгчийн аялж амьдарч байсан хотуудын газар нутаг, зохиолч Эдгар Алан Погийн бүтээл дэх геометрийн дүрсүүд, Сүрэнгийн ааваасаа бэлэг болгон авсан үнэг, өвөө эмээгийнх нь ярьж байсан үлгэрүүд, мөн өндөр өвөг Урансүрэнгийн нь хийж асан сийлбэр бурхнаас санаа авсан ажлууд багтсан болно.

“Дурсамжаар бүтээв” цуврал үзэсгэлэнгийн үндсэн холбогч нь “Цагаан уул” цэцэг бөгөөд “Цагаан уул”-ыг монголчууд бид үхэшгүй мөнхийн цэцэг хэмээн бэлгэшээдэг. Үүгээр өөрийнх нь дурсамжид үлдсэн дотно хүмүүсээ эл цэцгийн адилаар үхэшгүй, үргэлж мөнхөд амьдралдаа байлгах хүслийг илтгэнэ.

Зохиогчийн сэдэл

Дурсамж нь миний хувьд ямар нэг эд зүйлээс илүүтэй ном, дуу авиа, хөгжим, үнэг, цэцэгс, ямар нэг газрууд байдаг. Оюутан болж Болонья руу зураасан зургаар (бар зураг) сурах хүсэлдээ хөтлөгдөн явах үеэр би цөөнгүй хайртай хүнээсээ хагацсан юм. Тэр цагаас хойш зуны амралтаараа Улаанбаатарт ирэх бүртээ тэднийхээ гэрэл зургуудыг үзэх маань ихэсч, дурсан санахдаа тэдний хэрэглэж байсан жижиг сажиг зүйлсийг нь цуглуулж эхэлсэн. Энэ нь 2013-2016 он. Ийнхүү өнгөрсөнд байсан тэдгээр дотно хүмүүсийн гэгээн дурсамж, миний амьдарсан хот хоёр нийлэн тус үзэсгэлэнд дэлгэгдсэн бүтээлүүдийг хийх шалтгаан болсон юм.

Хүн бүхэнд мартахыг хүсдэггүй дурсамж гэж байдаг болов уу. Гагцхүү үзэгч та энэ үзэсгэлэнгээр дамжин дотно дурсамжуудаа дулаан хэвээр нь ахин нэг санаасай хэмээн би хүсч байна.

The Concept of the Work

“Made by Memory” is a five-part piece inspired by past memories formed with contemporary to past viewpoints of navel gazing concept at its core shown by the artist H. Suren from 2020-2021. “Made by Memory” Part 1 exhibition’s main elements were created during H. Suren’s years spent in Italy when she attended a school in Bologna from 2013-2016 and the rest of the works are from 2020.

All items were created using fine arts printing as well as embroidery techniques. The contents of this piece convey distinctive visuals such as the various places the artist inhabited or journeyed through the years, writer Edgar Allan Poe’s geometric shapes found in his literature, the felt fox ornament gifted by the artist’s father, tales told by the artist’s grandparents from long ago in addition to the gods inspired pieces carved by the artist’s paternal great grandfather.

The flower “White Mountain ” which entails an eternal immortality greatly heralded by Mongolians interconnects the five-part “Made by Memory” series. In the same vein as what the flower symbolizes, the artist illustrates the innate desire within her to preserve the souls buried in her memories as alive as evermore.

The Artist’s Motives

Memories represent the utmost vital aspects of life to me. Entities like books, music, fox, flowers and sites mean more to me than mere objects. When I moved to Bologna, Italy to inquire knowledge and study in the field of printmaking, which is my paramount passion I had to dismantle a relationship from someone I loved dearly. Ever since those days I’d flip through photos during my summer break in UB and really cherish the items that were once used. These intervals occurred from 2013-2016. Therefore the people that inhabited my past and the city I treasure became the core objectives for me to showcase my piece.

Does everyone have memories they yearn to keep in their hearts forever? I hope for you viewers to reminiscence and relish in the memories that hold you with such captivity as mine does.

MADE BY MEMORY

First Chapter

Кураторын үг

Сүрэнгийн талаарх дурсамж надад тод үлдсэн байдаг. Бүтээлийнхээ талаар намдуу зөөлөн хоолойгоор тайлбарлаж байсан мөчүүдийг эргэн дурсахад туйлын таатай байна. Өөрийгөө тодорхойлсончлон тэрээр анхандаа бүрэг ичимхий, суралцах барил алгуур, зориг муутайхан санагддаг байлаа. Түүнчлэн эх орондоо олж авсан туршлага болоод Итали дахь орчин, ахуй хоорондын ялгаа хийгээд ижил төстэй байдлыг олон талаас нь эргэцүүлэх хэрэгтэй байв. Эцэст нь шаргуу зүтгэлийнхээ үр дүнд тэрээр өөрийн бүтээлч чанараа нээн гаргаж, өөртөө итгэх итгэл, бие даасан байдлаа олж авсан билээ.

Сүрэнгийн бүтээлийн гол санаа нь түүний хөрөг юм. Тэрээр бүтээлдээ оршин байхыг, гол дүр нь болохыг, эргэн дурсахыг хүсдэг. Аква форте, черамолле, модон бар, акватинта зэрэг аргаар бүтээлээ туурвиж болох байсан ч энгийн, хялбар аргыг бус санааг нь бүрэн илэрхийлж, төлөөлж чадахуйц илүү нарийн цогц арга ашиглахыг зорьсон нь түүний онцлог. Энэ зорилго нь Сүрэнг уламжлалт хэв маягаас гадна өнгийг чухалчилж хослуулах өөрийн гэсэн өвөрмөц урлагийн хэв маягт хөтөлж, давтагдашгүй, цор ганц нээлт болохуйц бүтээл туурвихад хүргэсэн билээ.

Түүнчлэн төрөлх нутгийнх нь, бага насных нь дурсамжийг санагдуулдаг тул оёдлын техникт ихээр татагдан дурласан болов уу. Өнгөний зохицол хэмнэл зэрэг нь түүний дулаан, гэрэл гэгээтэй багын дурсамжийг нь илтгэж, өнгөрсөн бүгд хэчнээн чухал болохыг хүүрнэнэ.

Куратор
Prof. Каталдо Серафини
Болонья, Итали Ул

The Curator's Note

Even though a few years have passed, Suren's memory remains intact. I am pleased to remember her, discussing her work is like recalling didactic moments in a soft tone. As she used to say, her shyness was evident, but over time she found a way to melt the glacier and began to feel liberated, and really come into her own. The beginning phase, that of learning, was gradual, but she gained confidence and autonomy with triumph. She had to comprehend how to relate to the environment, so different and free compared to what she had experienced in Mongolia. Timidly she proceeded to acquire the techniques and to cultivate her personal creativity.

The main subject was the figure who became her portrait. She yearned to be present and longed to be the protagonist, and always remember. Eternally orating soft dialogues, objectives were established where the technique didn't wish to linger simply, etching, soft-wax, aquatint, xylography, but to further reach towards a complex composition that best embodies her idea of graphics. Her research led her to a unique style of her own art, where color becomes vital beyond traditional techniques. We established that it had to be a distinctive yet solitary mediation.

The sewing technique is a process that fascinated her, above all it is a reference to her idea of Mongolia. The rhythm, the contrast of the colors, reminds one of that light from her childhood that warms her affections and memories, which more than anything else remains an anchored part of her being.

Curator
Prof. SERAFINI Cataldo
Bologna, Italy

Барлах урлагийн тухай товч

Барлах урлагийн гол техник нь матриц (хавтан)-д барласан дүрсээ босоо даралтаар даавуу, чийгтэй цаас зэрэгт буулгадаг. Хавтанг ихэнхдээ нимгэн зэс эсвэл цайран ялтсаар хийдэг. Гараар болон хүчлээр идүүлэн сийлбэрлэж дүрс гаргаж буйг барлах гэх бөгөөд энэ арга нь XV зуунд Итали, Герман зэрэг улсад үүссэн бөгөөд Гутенбергийн хөдөлгөөнт хэв (movable type) гэж нэрлэх нь ч бий. Мөн алт, мөнгө, зэвсгийн дархчууд, ном хэвлэхэд гол төлөв хэрэглэдэг мөнгөн ялтаст хэвийг сийлбэрлэн барлах Булино арга байдаг ба үүнийг "Бурины техник" ч гэдэг. Анхлан номыг олноор хэвлэх үед "Бурины техник"-ийг ашигладаг байсан бол Гутенбергийн хөдөлгөөнт хэвийн арга нь энэ ажлыг хөнгөвчлөхөд ихээхэн тусалсан.

Улмаар металыг хүчлээр идүүлж, сийлбэрлэн барлах арга дэлгэрсэн нь зураачид бүтээлээ туурвих, түгээн дэлгэрүүлэхэд томоохон дэвшил болсон. "Сийлбэрт хэвний техник"-ийн томоохон үндэслэгчийг Рембрандт гэж үздэг. Энэ техник нь одоог хүртэл график урлагт үндсэн аргаар ашиглагддаг бөгөөд хэвлэлийн технологид гравюр (engravings) хэмээн нэрлэдэг.

Уран бүтээлч Х.Сүрэнгийн тус үзэсгэлэнд дэлгэсэн ажлуудад дан болон холимог төмөр барын төрлүүд, модон бар, торгон хэвлэл, экспериментал техникүүдийг ашигласан.

A Brief Introduction of Printmaking

Printmaking: Printing process carried out by vertical pressure between two rollers on a surface with cloth and damp paper. The pressure exerted is considerable so that the paper can touch and hold the ink of the engraved design contained on the matrix. The design, engraved manually or through the action of acid. The matrix, a copper or zinc metal plate, with a thin thickness. This process was born in the fifteenth century in Italy and Germany at the same time, as Gutenberg's invention of movable type. The engraved design, a necessary creation for the production of books, a method practiced by "goldsmiths and gunsmiths". The drawings were on silver plates engraved with the "Bulino" better known as "Burin Technique". The movable type of Gutenberg, facilitated the production of books for a greater diffusion.

In the first phase of the creation of the book, the technique used was that of goldsmiths and gunsmiths, as mentioned above, with the burin technique. The figure of the engraver was necessary for the creation of the drawing on the plate, made by the professional painter. A few decades later slabs were made with the use of acid, this method allowed the artist painter to make the drawing on the matrix, personally. Rembrand was the author who best represents the "Etching Technique". Still today the etching technique is the main technique, the prints and "Engravings", all this is the "Printmaking".